



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛ



Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаяг эсхүл дээрх QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

АГУУЛГА

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ	3-4
НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ	5
1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:	5
1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ:	10
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ	11
2.1. Нэгдсэн төсвийн орлого:	11
2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага:	15
ГУРАВ. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР.	16
ДӨРӨВ. ГАДААД ХУДАЛДАА	17
4.1. Гадаад худалдааны үндсэн үзүүлэлтүүд:	17
4.2. Экспорт:	20
4.3. Импорт:	24
ТАВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	27
5.1. Мөнгөний нийлүүлэлт:	27
5.2. Гадаад валютын албан нөөц:	29
5.3. Төлбөрийн тэнцэл:	30
ЗУРГАА. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ	32
6.1. Хүн ам, ажил эрхлэлт:	32
6.2. Ажилгүйдэл:	32



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ



Эдийн засаг 7.0 хувиар өсжээ. Эдийн засгийн өсөлт 2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр 5.0 хувьтай гарч байсан бол 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 7.0 хувьд хүрч, 2.0 нэгж хувиар өссөн байна. Энэхүү өсөлтөд тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, уул уурхай, мэдээлэл холбооны салбарын өсөлт голлон нөлөөлжээ.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ашигтай гарсан байна. 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн нийт дүн 23,217.9 тэрбум төгрөг, төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 22,454.5 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 763.4 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хэмжээ 1.1 хувь болж өмнөх оноос 3.0 нэгж хувиар өссөн нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн хэмжээ 1,796.2 тэрбум төгрөгөөр өсөж, 763.4 тэрбум төгрөгийн ашигтай гарсантай холбоотой байна.

Төсвийн орлого: Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 23,217.9 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 6,091.0 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн бол тайлант хугацааны орлогын төлөвлөгөөний биелэлт 105.6 хувьтай байна.

Төсвийн нийт зарлага: Нэгдсэн төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүн 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 22,454.5 тэрбум төгрөгт хүрч, 92.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь өмнөх оноос 4,294.8 тэрбум төгрөгөөр буюу 23.7 хувиар нэмэгдсэн байна.

Засгийн газрын өр: Засгийн газрын өрийн хэмжээ 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 30,765.0 тэрбум төгрөг байна. Өнгөрсөн оны урьдчилсан гүйцэтгэлтэй харьцуулахад 1,199.8 тэрбум төгрөгөөр буюу 3.8 хувиар буурсан байна.

Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарлаа. 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 24,437.0 сая ам.доллар, экспортын худалдаа 15,184.5 сая ам.доллар, импортын худалдаа 9,252.5 сая ам.доллар болж, гадаад худалдааны тэнцэл 5,932.0 сая ам.долларын ашигтай гарсан. 2021-2023 онд экспорт жилд дунджаар 26.3 хувиар, импорт 20.9 хувиар өссөн байна. Өнгөрсөн оны гүйцэтгэлтэй харьцуулахад 2023 онд экспорт 2,645.9 сая ам.доллар буюу 21.1 хувиар, импорт 548.1 сая ам.доллар буюу 6.3 хувиар тус тус өссөн байна. 2023 онд эрдэс бүтээгдэхүүний экспорт 13,145.6 сая ам.доллар болж, 2,602.3 сая ам.доллар буюу 24.7 хувиар өссөн нь нийт экспортын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Мөнгөний нийлүүлэлт өслөө. Мөнгөний нийлүүлэлт 2023 оны 12 дугаар сарын байдлаар 37,624.1 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 7,959.3 тэрбум төгрөг буюу 26.8 хувиар өссөн байна. Өнгөрсөн онтой харьцуулахад мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд төгрөгийн харилцах 2,577.4 тэрбум төгрөг буюу 40.5 хувиар, төгрөгийн хадгаламж 4,529.4 тэрбум төгрөг буюу 36.0 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 12 дугаар сард улсын хэмжээнд 7.9 хувьтай гарч, өмнөх оны мөн үеэс 5.3 нэгж хувиар буурсан байна.

Төлбөрийн тэнцэл ашигтай гарлаа. 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр урсгал тэнцэл 244.5 сая ам.доллар, хөрөнгийн тэнцэл 135.2 сая ам.доллар, санхүүгийн тэнцэл 1,376.0 сая ам.долларын тус тус ашигтай гарсан. Төлбөрийн тэнцлийн урсгал тэнцэл, хөрөнгө ба санхүүгийн тэнцлүүд ашигтай гарсан нь төлбөрийн тэнцэл нийт дүнгээрээ 1,457.0 сая ам.долларын ашигтай гарахад нөлөөлжээ. Төлбөрийн тэнцэл өнгөрсөн оноос 2,184.2 сая ам.доллороор сайжирсан байна.

Гадаад валютын нөөц өслөө. Нийт албан нөөцийн хэмжээ 2023 оны эцсээр 4,921.5 сая ам.доллар болж, өнгөрсөн оноос 1,522.0 сая ам.доллар буюу 44.8 хувиар өссөн байна. Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2023 оны эцсийн байдлаар 4,921.5 сая ам.доллар болж нийт импортын 6.4 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрсэн байна.

Гадаад валютын ханш: Төгрөгийн ам.доллартой харьцах нэрлэсэн ханш 2023 оны 12 дугаар сард 3,421.0 төгрөг болж, өмнөх оноос 10.1 төгрөгөөр чангарсан байна. Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш 476.0 төгрөг болж, өмнөх оноос 12.9 төгрөгөөр мөн чангарсан байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл: 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр хугацаа хэтэрсэн зээл 1,272.7 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оноос 144.0 тэрбум төгрөг буюу 12.8 хувиар өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.6 хувийг эзэлж, өнгөрсөн оноос 0.5 нэгж хувиар буурсан байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээлийн хэмжээ: 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр чанаргүй зээлийн хэмжээ 2.0 их наяд төгрөг болж, өнгөрсөн оноос 12.2 тэрбум төгрөг буюу 0.26 хувиар буурчээ. Чанаргүй зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.4 хувийг эзэлж байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:


Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ:

2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр бодит ДНБ-ий хэмжээ 2015 оны зэрэгцүүлэх үнээр 30.5 их наяд төгрөг болж, 7.0 хувьд хүрсэн байна.

2021 оны эхний улиралд ДНБ-ий бодит өсөлт 14.8 хувьд хүрч уналтын дараах сэргэлт (V хэлбэрийн сэргэлт) гарсан хэдий боловч энэхүү өсөлт 2022 оны эхний улиралд хүртэлх хугацаанд саарч, 2022 оны 2 дугаар улиралд өсөж 1.9 хувьд хүрч байсан бол 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 7.0 хувийн өсөлттэй гарлаа.

График 1-д 2016-аас 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр ДНБ-ий хэмжээ болон мөн хугацааны улирал бүрийн эдийн засгийн бодит өсөлтийн хоорондох хамаарлыг харуулав.

График 1. Нэрлэсэн ДНБ-ий хэмжээ ба ДНБ-ий бодит өсөлт, улирлаар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол Улсын экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын хэмжээ болон олон улсын зах зээлийн үнэ тус тус нэмэгдсэнээр макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, ялангуяа эдийн засгийн бодит өсөлт сайжрах төлөвтэй байна.

2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 68.9 их наяд төгрөг болж, өмнөх оноос 27.9 хувь буюу 15.0 их наяд төгрөгөөр өссөн бол 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ-ий хэмжээ 30.5 их наяд төгрөг болж, өмнөх оноос 7.0 хувь буюу 1.9 их наяд төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтөд тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, уул уурхай, мэдээлэл холбооны салбарын өсөлт голлон нөлөөлжээ.


Өмнөх онтой харьцуулахад уул уурхайн салбар 38.7 хувиар, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 30.1 хувиар, мэдээлэл холбоо 9.8 хувиар тус тус өссөн бол хөдөө аж ахуйн салбар 20.9 хувиар буурчээ.

Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлтийн хувь, салбараар /өмнөх оны мөн үетэй харьцуулахад/

Үзүүлэлт	Жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр											
	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
ДНБ-ий бодит өсөлт	12.3	11.6	7.9	2.4	1.5	5.6	7.7	5.6	-4.6	1.6	5.0	7.0
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	21.1	19.2	13.7	10.7	5.4	-0.3	6.5	5.3	5.8	-5.5	12.0	-8.9
Уул уурхай, олборлолт	8.3	18.5	19.4	14.1	-1.6	-3.9	5.4	-1.6	-9.9	0.8	-15.3	23.4
Боловсруулах үйлдвэрлэл	8.7	10.3	4.2	2.6	-7.2	16.4	19.5	3.8	3.4	-0.9	6.1	5.1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	4.2	5.4	5.3	3.1	3.0	4.4	7.0	6.3	1.8	9.4	3.3	5.0
Барилга	85.3	8.0	-4.3	-0.2	-0.4	-1.3	1.8	20.3	-3.2	-22.8	8.2	0.6
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	12.0	8.9	2.4	-8.1	-0.2	8.2	0.1	10.9	-12.5	5.8	10.1	5.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	8.1	-1.4	14.8	5.1	6.5	1.0	14.6	4.4	-18.2	-7.3	9.2	39.3
Мэдээлэл, холбоо	16.2	14.9	4.7	-2.5	1.1	-4.5	12.1	12.1	5.2	20.7	6.6	16.4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	9.0	9.3	10.2	5.8	3.4	8.8	4.8	4.6	-2.6	3.8	5.4	5.2
Бүтээгдэхүүний цэвэр татвар	7.2	11.1	-8.1	-22.1	2.6	23.3	20.4	9.6	-9.4	12.2	11.5	6.8


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 2. Нэрлэсэн ДНБ, өөрчлөлт, оны үнээр, их наяд төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 3. Бодит ДНБ, өөрчлөлт, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, их наяд төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эдийн засгийн өсөлт 2020 оны гүйцэтгэлээр -4.6 хувьтай гарч байсан бол 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 5.0 хувь, мөн 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 7.0 хувь болж тус тус өссөн байна. Энэ өсөлт нь 2019 оны мөн үе буюу ковидын өмнөх үеэс 1.6 нэгж хувиар өссөн үзүүлэлт боллоо.

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ:

Оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 70.4 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оноос 28.4 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 30.4 их наяд төгрөг болж өнгөрсөн оноос 7.1 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 2. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, оны үнээр, өссөн дүнгээр

Үзүүлэлт	2018-IV	2019-IV	2020-IV	2021-IV	2022-IV	/тэрбум төгрөгөөр/	
						2023-IV	Өөрчлөлт (хувиар)
ДНБ	32,582.6	37,839.2	37,883.0	44,702.7	54,877.8	70,444.4	28.4
Эцсийн хэрэглээ	23,019.1	26,627.5	28,570.0	29,580.8	35,422.9	42,087.0	18.8
Өрхийн хэрэглээ, Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ	18,883.4	21,667.6	22,648.6	23,085.5	27,927.5	32,947.1	18.0
Төрийн байгууллагын хэрэглээ	4,135.7	4,960.0	5,921.5	6,495.3	7,495.4	9,139.9	21.9
Хөрөнгийн нийт хуримтлал	12,830.4	13,467.7	8,383.4	15,993.2	22,796.5	22,305.4	-2.2
Үндсэн хөрөнгийн хуримтлал	8,746.9	10,588.7	8,830.8	11,688.3	16,055.1	18,857.0	17.5
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал	4,083.4	2,879.0	-447.4	4,304.9	6,741.4	3,448.4	-48.8
Цэвэр экспорт	-3,266.8	-2,256.0	929.6	-871.3	-3,341.6	6,052.0	-281.1
Бараа, үйлчилгээний экспорт	18,951.6	22,407.3	21,595.7	25,501.2	35,036.5	53,730.0	53.4
Бараа, үйлчилгээний импорт	22,218.5	24,663.3	20,666.1	26,372.5	38,378.2	47,678.0	24.2


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 3. Эцсийн ашиглалтын аргаар ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, өссөн дүнгээр

Үзүүлэлт	2018-IV	2019-IV	2020-IV	2021-IV	2022-IV	/тэрбум төгрөгөөр/	
						2023-IV	Өөрчлөлт (хувиар)
ДНБ	26,393.9	27,836.8	26,622.7	27,054.7	28,395.1	30,411.1	7.1
Эцсийн хэрэглээ	20,612.6	22,060.4	23,051.2	22,438.7	24,186.7	25,928.7	7.2
Өрхийн хэрэглээ, Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ	16,805.7	17,787.1	18,153.2	17,090.9	18,468.4	19,833.9	7.4
Төрийн байгууллагын хэрэглээ	3,806.8	4,273.3	4,898.0	5,347.8	5,718.2	6,094.9	6.6
Хөрөнгийн нийт хуримтлал	11,037.5	11,057.3	6,561.4	11,857.7	13,182.5	11,966.4	-9.2
Үндсэн хөрөнгийн хуримтлал	7,618.3	8,684.8	6,852.5	8,064.1	9,130.6	9,771.2	7.0
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал	3,419.3	2,372.4	-291.1	3,793.6	4,051.9	2,195.3	-45.8
Цэвэр экспорт	-5,256.2	-5,280.8	-2,989.8	-7,241.7	-8,974.1	-7,484.1	-16.6
Бараа, үйлчилгээний экспорт	12,852.4	14,391.7	13,634.0	11,638.7	15,395.0	22,004.4	42.9
Бараа, үйлчилгээний импорт	18,108.6	19,672.5	16,623.9	18,880.4	24,369.1	29,488.5	21.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 4. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, их наяд төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх онтой харьцуулахад эдийн засгийн бодит өсөлт 7.1 хувиар /эцсийн ашиглалтын аргаар тооцсон/ өсөхөд өрхийн болон төрийн байгууллагын хэрэглээ өссөн нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 4. ДНБ-ий бодит өсөлт, салбараар, хувиар

Үзүүлэлт	Жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр							
	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
ДНБ	1.5	5.6	7.6	5.5	-4.4	1.6	5.0	7.1
Эцсийн хэрэглээ	4.0	2.9	9.6	7.0	4.5	-2.7	7.8	7.2
Өрхийн хэрэглээ, Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ	1.8	4.3	11.7	5.8	2.1	-5.9	8.1	7.4
Төрийн байгууллагын хэрэглээ	13.3	-2.4	1.1	12.3	14.6	9.2	6.9	6.6
Хөрөнгийн нийт хуримтлал	-1.8	31.6	52.1	0.2	-40.7	80.7	11.2	-9.2
Үндсэн хөрөнгийн хуримтлал	7.7	28.2	31.8	14.0	-21.1	17.7	13.2	7.0
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал	-29.5	46.7	131.6	-30.6	-112.3	-1,403.0	6.8	-45.8
Цэвэр экспорт	87.3	177.4	243.8	0.5	-43.4	142.2	23.9	
Бараа, үйлчилгээний экспорт	15.5	3.7	6.1	12.0	-5.3	-14.6	32.3	42.9
Бараа, үйлчилгээний импорт	17.5	11.5	32.7	8.6	-15.5	13.6	29.1	21.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

1.2. Нэг хүнд ногдох ДНБ

Бүтээмжийг нэг ажиллагчид ногдох бодит ДНБ-ээр илэрхийлдэг. Бүтээмжийг 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцоолоход 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 6.9 сая төгрөг болж, өмнөх оноос 3.2 хувиар буюу 255.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Салбараар нь авч үзвэл, үйлчилгээний салбарын бүтээмж 289.8 мянган төгрөг (5.1 хувь)-өөр, хөдөө аж ахуйн салбарын бүтээмж 112.5 мянган төгрөг (3.7 хувь)-өөр тус тус нэмэгдсэн боловч аж үйлдвэр, барилгын салбарын бүтээмж 854.7 мянган төгрөг (9.6 хувь)-өөр, уул уурхайн салбарын бүтээмж 314.0 мянган төгрөг (1.8 хувь)-өөр тус тус буурчээ.

Хүснэгт 5. Нэг хүнд ногдох ДНБ буюу бүтээмжийн харьцуулалт

Бүрэлдэхүүн	Жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр						Өөрчлөлт 2023/2022	
	2018	2019	2020	2021	2022	2023	Дүн	Хувь
Хөдөлмөрийн бүтээмжийн түвшин	5,614.0	6,112.1	6,538.6	6,265.9	6,602.2	6,857.5	255.3	3.9
Хөдөө аж ахуй	2,023.4	2,893.5	2,990.7	2,639.2	3,018.8	3,131.3	112.5	3.7
Уул уурхай, олборлолт	22,132.3	20,154.9	30,283.7	19,940.6	17,121.3	16,807.3	(314.0)	(1.8)
Аж үйлдвэр, барилга	7,301.2	7,856.7	9,494.2	8,451.8	8,869.7	8,015.0	(854.7)	(9.6)
Үйлчилгээ	4,820.6	5,103.3	4,822.6	5,244.0	5,702.4	5,992.2	289.8	5.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 23,217.9 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүн 22,454.5 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 763.4 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оноос 6,091.0 тэрбум төгрөг буюу 35.6 хувиар, төсвийн нийт зарлага 4,294.8 тэрбум төгрөг буюу 23.7 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 6. Монгол Улсын нэгдсэн төсөв

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Биелэлт, хувиар	Өөрчлөлт(+/-)	
		2023.12/2022.12			(3-2)	(3-2)/2
	1	2	3	(3:1)	(3-2)	(3-2)/2
	2023.12	2022.12	2023.12	Төл/гүйц	Дүн	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	21,983.6	17,126.9	23,217.9	105.6	6,091.0	35.6
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	24,228.9	18,159.7	22,454.5	92.7	4,294.8	23.7
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	-2,245.4	-1,032.7	763.4	-34.0	1,796.2	-173.9
ДНБ, оны үнээр		53,851.5	68,871.7		15,020.2	
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь		-1.9	1.1		3.0	

Эх сурвалж: Сангийн яам, Үндэсний статистикийн хороо

2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын бүрдүүлэлт 105.6 хувийн, нийт зарлага 92.7 хувийн гүйцэтгэлтэй гарч, нийт тэнцэл 763.4 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хэмжээ 1.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс 3.0 нэгж хувиар өссөн нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн хэмжээ 1,796.2 тэрбум төгрөгөөр өсөж, 763.4 тэрбум төгрөгийн ашигтай гарсантай холбоотой байна.

2.1. Нэгдсэн төсвийн орлого:

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 23,217.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 35.6 хувиар буюу 6,091.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 1,234.3 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Тэнцвэржүүлсэн нийт орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал тус бүрээр авч үзвэл улсын төсөв 5.7 хувь буюу 867.2 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсөв 5.5 хувь буюу 253.5 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн төсөв 2.1 хувь буюу 86.4 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн бол, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 0.9 хувь буюу 14.8 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 56.8 хувь буюу 5,816.7 тэрбум төгрөг, орон нутгийн төсөв 60.7 хувь буюу 1,833.3 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сан 21.3 хувь буюу 749.1 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 29.7 хувь буюу 364.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 7. Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр, төсвийн шатлалаар


/тэрбум төгрөгөөр/

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
Нийт орлого ба тусламжийн дүн	16,226.2	17,144.0	4,602.2	4,855.7	4,175.2	4,261.6	1,603.5	1,588.7
Ирээдүйн өв сан	540.0	416.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тогтворжуулалтын сан	501.6	675.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	15,184.6	16,051.8	4,602.2	4,855.7	4,175.2	4,261.6	1,603.5	1,588.7
Татварын орлого	12,459.0	13,725.7	3,445.6	3,782.2	3,400.8	3,497.3	1,603.5	1,588.7
Татварын бус орлого	2,725.6	2,326.1	1,156.6	1,073.5	774.4	764.4	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 92.4 хувийг татварын орлого, 7.6 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Хүснэгт 5. Татварын болон татварын бус орлого /хувиар/




2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр Тогтворжуулалтын санд 501.6 тэрбум, Ирээдүйн өв санд 540.0 тэрбум төгрөг хуваарилахаар төлөвлөснөөс Тогтворжуулалтын санд 675.9 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 416.2 тэрбум төгрөг хуваарилсан байна. Тогтворжуулалтын санд төвлөрүүлэх орлого 34.7 хувиар буюу 174.3 тэрбум төгрөгөөр давж биелсэн бол Ирээдүйн өв сангийн хөрөнгө 22.9 хувийн буюу 123.8 тэрбум төгрөгийн дутуу биелэлттэй байна.

Нэгдсэн төсвийн татварын орлого 21,450.8 тэрбум төгрөг болж, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 8.6 хувиар буюу 1,704.0 тэрбум төгрөгөөр давж биелсэн, өмнөх оны мөн үеэс 38.8 хувь буюу 5,991.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Татварын орлого: Татварын орлогын 27.0 хувийг орлогын албан татвар, 18.4 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.9 хувийг хөрөнгийн албан татвар, 22.3 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 3.7 хувийг онцгой албан татвар, 0.1 хувийг тусгай зориулалтын орлого, 6.8 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 19.9 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлсэн байна.

График 6. Татварын орлого /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Сангийн яам


2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр татварын орлого төлөвлөснөөс 8.6 хувь буюу 1,704.0 тэрбум төгрөгөөр давж биелэхэд орлогын албан татвар 23.3 хувь (1,096.9 тэрбум төгрөг), нийгмийн даатгалын орлого 2.6 хувь (100.7 тэрбум төгрөг), хөрөнгийн албан татвар 3.8 хувь (14.5 тэрбум төгрөг), тусгай зориулалтын орлого 8.1 хувь (1.6 тэрбум төгрөг), бусад татвар, төлбөр, хураамж 24.9 хувь (850.8 тэрбум төгрөг)-аар, нэмэгдсэн өртгийн албан татвар 1.5 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн нь нөлөөлжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр татварын орлого 38.8 хувь буюу 5,991.8 тэрбум төгрөгөөр өсөхөд орлогын албан татвар 51.6 хувь (1,973.3 тэрбум төгрөг), нийгмийн даатгалын орлого 29.8 хувь (904.6 тэрбум төгрөг), хөрөнгийн албан татвар 67.0 хувь (159.3 тэрбум төгрөг), нэмэгдсэн өртгийн албан татвар 21.0 хувь (827.2 тэрбум төгрөг), гадаад үйл ажиллагааны орлого 16.6 хувь (208.6 тэрбум төгрөг), бусад татвар, төлбөр, хураамж 86.3 хувь (1,974.4 тэрбум төгрөг), тусгай зориулалтын орлого 11.7 хувь (2.3 тэрбум төгрөг)-аар тус тус өссөн нь нөлөөлжээ.

2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр татварын бус орлого 1,767.2 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 99.2 тэрбум төгрөгөөр буюу 5.9 хувиар өссөн бол төлөвлөснөөс 469.7 тэрбум төгрөг буюу 21.0 хувиар дутуу төвлөрчээ.

Татварын бус орлого: Татварын бус орлогын 80.9 хувийг нийтлэг татварын бус орлого, 18.6 хувийг тусламжийн орлого, 0.4 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. Нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 34.9 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 21.3 хувийг газрын тосны орлого, 15.6 хувийг хүүгийн орлого, 8.6 хувийг бусад орлого, 12.7 хувийг хувьцааны ноогдол ашиг, 6.1 хувийг торгуулийн орлого, 0.5 хувийг түрээсийн орлого, 0.3 хувийг навигацыйн орлого бүрдүүлж байна.

График 7. Татварын бус орлогын бүтэц, хувиар



Эх сурвалж: Сангийн яам

Төлөвлөгөөтэй харьцуулахад гадаад хандив тусламжийн орлого 269.6 тэрбум төгрөгөөр, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 11.7 тэрбум төгрөгөөр дутуу биелэлтэй байна.

Нийтлэг татварын бус орлогоос төсөвт байгууллагын өөрийн орлого 140.3 тэрбум төгрөг, торгуулийн орлого 36.5 тэрбум төгрөгөөр, түрээсийн орлого 2.5 тэрбум төгрөгөөр давж биелсэн бол навигацыйн орлого 145.0 тэрбум төгрөгөөр, газрын тосны орлого 120.8 тэрбум төгрөгөөр, бусад орлого 53.1 тэрбум төгрөгөөр, хүүгийн орлого 41.8 тэрбум төгрөгөөр, хувьцааны ноогдол ашгийн орлого 7.2 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн байна.

2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага

2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 24,228.9 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 92.7 хувийг зарлагадаж, 1,774.5 тэрбум төгрөгийн дутуу зарцуулалттай байна. Өмнөх онтой харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 4,294.8 тэрбум төгрөг буюу 23.7 хувиар өсөж, 22,454.5 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

Хүснэгт 8. Нэгдсэн төсвийн зарлага

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	Гүйцэтгэл /2022.12/	2023 оны урьдчилсан гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Хувь	Зөрүү
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	18,159.7	24,228.9	22,454.5	92.7	-1,774.5
Нийт зарлага	18,032.7	24,289.0	22,221.5	91.5	-2,067.5
Урсгал зардал	14,229.3	18,071.4	17,046.6	94.3	-1,024.8
Бараа, ажил үйлчилгээний зардал	3,806.0	5,475.1	5,062.1	92.5	-413.0
Хүү	797.8	1,151.6	1,131.7	98.3	-19.9
Татаас	537.1	797.8	579.7	72.7	-218.1
Урсгал шилжүүлэг	9,088.5	10,646.9	10,273.1	96.5	-373.8
Хөрөнгийн зардал	3,803.4	6,217.6	5,174.9	83.2	-1,042.7
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	127.0	-60.0	233.0	388.1	293.1

Эх сурвалж: Сангийн яам

Өнгөрсөн онтой харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 19.8 хувиар буюу 2,817.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нэгдсэн төсвийн зарлагын 75.9 хувь буюу 17,046.6 тэрбум төгрөг нь урсгал зардал, үүний дотор 60.3 хувийг урсгал шилжүүлэг, 29.7 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 6.6 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 3.4 хувийг татаас тус тус эзэлж байна.

Өнгөрсөн онтой харьцуулахад бараа, ажил үйлчилгээний зардал 1,256.1 тэрбум төгрөг, урсгал шилжүүлэг 1,184.6 тэрбум төгрөг, зээлийн үйлчилгээний төлбөр 333.9 тэрбум төгрөгөөр, татаас 42.6 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Түүнчлэн хөрөнгө оруулалтын зардал 1,371.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 35.6 хувь буюу 6,091.0 тэрбум төгрөгөөр, төсвийн нийт зарлага 23.7 хувь буюу 4,294.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, төсвийн зарлагын өсөлт орлогын өсөлтөөс 11.9 нэгж хувиар бага гарсан нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 1,796.2 тэрбум төгрөгөөр буурахад нөлөөлжээ.

ГУРАВ. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д “Засгийн газрын өр”-ийг тодорхойлсон, тухайлбал 4.1.8.а-д өрийн хэрэгслээр үүсгэж, Монгол Улсын Засгийн газар, аймаг, нийслэлээс бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргийг, 4.1.8.б-д хууль болон гэрээнд заасны дагуу гаргасан Засгийн газрын өрийн баталгааны дүнг” гэж тодорхойлсон. Засгийн газрын дотоод өр гэж өрийн хэрэгслээр үүсгэж, Монгол Улсын Засгийн газраас бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргийг, Засгийн газрын гадаад өр гэж Монгол Улсын Засгийн газрын эдийн засгийн харьяат бус аливаа этгээдэд төлөх өрийн хэрэгслээр үүсгэгдсэн төлбөрийн үүргийг тус тус ойлгоно.

Хүснэгт 9. Засгийн газрын өр

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	Жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр								
	2015	2016	2017	2018	2019	2020	2021*	2022*	2023*
I. Засгийн газрын дотоод өр	3,539.0	5,796.0	3,461.9	1,564.7	1,399.6	1,136.6	657.3	1,035.5	234.1
Үнэт цаас	3,333.2	5,488.8	3,461.9	1,564.7	1,399.6	1,136.6	657.3	1,035.5	234.1
II. Засгийн газрын гадаад өр ¹	7,881.2	12,363.8	16,857.8	18,865.6	20,443.5	24,848.1	24,687.9	29,641.6	30,319.5
Үнэт цаас	3,315.8	5,380.5	7,701.6	7,664.5	7,927.2	8,354.0	8,175.6	9,359.8	9,371.7
Зээл	4,565.4	6,983.3	9,156.2	11,201.1	12,516.3	16,494.1	16,512.3	20,281.8	20,947.8
III. Засгийн газрын бусад өр	3,004.5	4,120.4	2,432.0	1,936.7	2,072.0	1,910.6	1,550.4	1,287.7	211.4
Засгийн газрын өрийн баталгаа	2,743.5	3,451.5	1,663.8	1,130.7	1,076.3	1,060.4	876.5	811.9	30.9
Барих-шилжүүлэх концесс	261.0	668.9	768.2	806.0	995.7	850.2	673.9	463.5	180.5
Орон нутгийн зээллэг	-	-	-	-	-	-	-	12.3	-
Засгийн газрын нэрлэсэн өрийн үлдэгдэл (I+II+III)	14,424.7	22,280.2	22,751.7	22,367.0	23,915.1	27,895.3	26,895.6	31,964.8	30,765.0
Засгийн газрын өрийн үлдэгдэл (ӨҮЦ)	-	-	-	-	-	23,024.3	21,837.3	27,690.6	26,642.8

Эх сурвалж: Сангийн яам, Үндэсний статистикийн хороо

Засгийн газрын өрийн хэмжээ 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 30,765.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 1,199.8 тэрбум төгрөгөөр буюу 3.8 хувиар буурсан байна. Үүнд, Засгийн газрын дотоод үнэт цаас 801.4 тэрбум төгрөгөөр буюу 77.4 хувиар, Засгийн газрын бусад өр 1,076.3 тэрбум төгрөг буюу 83.6 хувиар, үүн дотроо Засгийн газрын өрийн баталгаа 781.0 тэрбум төгрөгөөр буюу 96.2 хувиар, барих-шилжүүлэх концесс 283.0 тэрбум төгрөгөөр буюу 61.1 хувиар тус тус буурсан нь нөлөөлжээ.


Засгийн газрын өрийн хэмжээг ковидын өмнөх үе буюу 2019 онтой харьцуулахад 6,849.9 тэрбум төгрөгөөр буюу 28.6 хувиар өссөн байгаа ба үүнд Засгийн газрын гадаад өр 9,876.0 тэрбум төгрөгөөр өссөн (гадаад үнэт цаас 1,444.5 тэрбум төгрөг, гадаад зээл 8,431.5 тэрбум төгрөг) нь нөлөөлжээ.

ДӨРӨВ. ГАДААД ХУДАЛДАА

Монгол Улс 2023 оны жилийн эцсийн байдлаар 160 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ 24,437.0 сая ам.долларт хүрсэн нь 2019 онтой харьцуулахад 10,689.9 сая ам.доллар буюу 77.8 хувиар, өнгөрсөн оноос 3,194.0 сая ам.доллар буюу 15.0 хувиар тус тус өссөн байна.

Гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ ковидын өмнөх түвшингээс давж, гадаад худалдааны тэнцэл сүүлийн 10 жил дараалан ашигтай гарлаа. Тухайлбал, гадаад худалдааны тэнцэл 2019 онд 1,492.1 сая ам.долларын ашигтай байсан бол 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 5,932.0 сая ам.долларт хүрч, бараг 4 дахин нэмэгдсэн байна.

График 8. Гадаад худалдааны үзүүлэлт, 2018-2023 оноор /тэрбум ам.доллар/




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

4.1. Гадаад худалдааны үндсэн үзүүлэлтүүд

2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 24,437.0 сая ам.доллар, экспортын худалдаа 15,184.5 сая ам.доллар, импортын худалдаа 9,252.5 сая ам.доллар болж, гадаад худалдааны тэнцэл 5,932.0 сая ам.долларын ашигтай тус тус гарсан нь “түүхэн дээд хэмжээ”-нд хүрсэн байна.

График 9. Экспорт, импортын өөрчлөлт /хувь/



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2019-2023 онд экспорт жилд дунджаар 17.4 хувиар, импорт 10.7 хувиар тус тус өссөн нь гадаад худалдааны нийт бараа эргэлт болон гадаад худалдааны ашиг нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Ялангуяа, 2021-2023 онд экспорт жилд дунджаар 26.3 хувиар, импорт 20.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өнгөрсөн оны гүйцэтгэлтэй харьцуулахад 2023 онд экспорт 2,645.9 сая ам.доллар буюу 21.1 хувиар, импорт 548.1 сая ам.доллар буюу 6.3 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 10. Гадаад худалдааны үндсэн үзүүлэлт, 2019-2023 оноор

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр					Өөрчлөлт	
	2019	2020	2021	2022	2023	Дүн	Хувь
Нийт эргэлт	13,747.1	12,858.1	16,086.6	21,243.0	24,437.0	3,194.0	15.0
Экспорт	7,619.6	7,576.3	9,241.1	12,538.6	15,184.5	2,645.9	21.1
Импорт	6,127.5	5,281.8	6,845.5	8,704.4	9,252.5	548.1	6.3
Тэнцэл	1,492.1	2,294.5	2,395.7	3,834.2	5,932.0	2,097.8	54.7

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл өнгөрсөн оноос 2,097.8 сая ам.доллороор өсөж 5,932.0 сая ам.долларын ашигтай гарсан. Импортыг экспортоор нөхөх коэффициент 2022 онд 144.0 хувь байсан бол 2023 онд 164.1 хувь болж, 20.1 нэгж хувиар нэмэгдлээ.

Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл: Валютын төлбөртэй экспорт нийт экспортын орлогын 98.8 хувь, валютын төлбөртэй импорт нь нийт импортын худалдааны 95.5 хувийг тус тус эзэлж байна.

Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 6,162.5 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 2,035.6 сая ам.доллар буюу 49.3 хувиар өссөн байна.

Валютын төлбөртэй экспортын орлого өнгөрсөн оноос 2,533.1 сая ам.доллар буюу 20.3 хувиар, валютын төлбөртэй импортын орлого 497.5 сая ам.доллар буюу 6.0 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 11. Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл

/сая ам.доллороор/

Үзүүлэлт	Жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр				Харьцуулсан хувь (2023/2022)
	2020	2021	2022	2023	
НИЙТ БАРАА ЭРГЭЛТ	12,875.2	16,086.0	21,243.00	24,437.0	115.0
А.Экспорт	7,576.3	9,241.1	12,538.60	15,184.5	121.1
А1.Валютын төлбөртэй бараа	7,529.6	9,179.9	12,462.90	14,996.0	120.3
Валютын төлбөртэй экспортын нийт экспортод эзлэх хувь	99.4%	99.3%	99.4%	98.8%	-
В.Импорт	5,298.9	6,845.5	8,704.40	9,252.5	106.3
В1.Валютын төлбөртэй бараа	5,014.0	6,557.7	8,336.00	8,833.5	106
Валютын төлбөртэй импортын нийт импортод эзлэх хувь	94.6%	95.8%	95.8%	95.5%	-
С. Тэнцэл (А-В):	2,277.4	2,395.7	3,834.20	5,932.0	154.7
Д. Импортыг экспортоор нөхөх коэффициент ((А/В)*100)	143.0	135.0	144.0	164.1	20.1
Е. Импортыг экспортоор нөхөх коэффициент ((А1/В1)*100)	150.0	140.0	150.0	170.0	20.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Экспорт, импортын жилийн өсөлт: Экспорт болон импортын жилийн өсөлтийн хурдыг 3 сарын гулсах дундаж (2011.01-2023.12)-аар тооцон үзэв.

2013 онд Оюутолгойн уурхайн төсөл эхэлж, олборлолт, борлуулалт хийснээр экспортын тоо хэмжээ 2014-2015 онуудад өссөн. 2020 оны эхний 5 сарыг эс тооцвол 2014 оны 10 сараас хойш гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан байна.

График 10. Гадаад худалдааны үзүүлэлтүүдийн өөрчлөлт



Хөрш орнуудтай хийсэн худалдаа: Монгол Улсын гадаад худалдаанд хөрш орнууд (ОХУ, БНХАУ) томоохон хувийг эзэлдэг. Тухайлбал, 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр хөрш орнууд нийлээд Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 82.2 хувь, экспортын 91.9 хувь, импортын 66.3 хувийг тус тус эзэлж байна. Үүнээс:

- БНХАУ-тай хийсэн худалдаа нь Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 72.0 хувь (17.6 тэрбум ам.доллар), экспортын 91.2 хувь (13.8 тэрбум ам.доллар), нийт импортын 40.5 хувь (3.7 тэрбум ам.доллар)-ийг эзэлжээ.

- ОХУ-ын хувьд гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 10.2 хувь (2.5 тэрбум ам.доллар), экспортын 0.7 хувь (111.2 сая ам.доллар), нийт импортын 25.8 хувь (2.4 тэрбум ам.доллар)-ийг эзэлж байна.

- 2023 онд БНХАУ-тай хийсэн худалдаа 10,095.5 сая ам.долларын ашигтай, ОХУ-тай хийсэн худалдаа 2,275.1 сая ам.долларын алдагдалтай байна.

Бусад улс оронтой хийсэн худалдаа гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 17.8 хувь, экспортын 8.1 хувь, импортын 33.7 хувийг эзэлж байна.

Хүснэгт 12. Хөрш орнуудын гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/


Улс орон	Төрөл	Эзлэх хувь /2023 он/	Жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэл					Өөрчлөлт (+/-)	
			2019	2020	2021	2022	2023	2023/2022	
								Дүн	Хувь
БНХАУ	Нийт эргэлт	72.0	8,850.6	7,403.8	10,158.6	13,646.8	17,595.3	3,948.5	28.9
	Экспорт	91.2	6,789.8	5,493.6	7,638.6	10,574.6	13,845.4	3,270.8	30.9
	Импорт	40.5	2,060.8	1,910.2	2,520.0	3,072.2	3,749.9	677.7	22.1
	Тэнцэл	-	4,729.0	3,583.4	5,118.6	7,502.4	10,095.5	2,593.1	34.6
ОХУ	Нийт эргэлт	10.2	1,797.9	1,457.2	2,068.0	2,704.9	2,497.5	-207.4	-7.7
	Экспорт	0.7	68.1	57.3	112.8	93.4	111.2	17.8	19.1
	Импорт	25.8	1,729.8	1,399.9	1,955.2	2,611.5	2,386.3	-225.2	-8.6
	Тэнцэл	-	-1,661.7	-1,342.6	-1,842.4	-2,518.1	-2,275.1	243.0	-9.7
Бусад	Нийт эргэлт	17.8	3,098.6	3,997.1	3,860.0	4,891.3	4,344.2	-547.1	-11.2
	Экспорт	8.1	761.7	2,025.4	1,489.7	1,870.6	1,227.9	-642.7	-34.4
	Импорт	33.7	2,336.9	1,971.7	2,370.3	3,020.7	3,116.3	95.6	3.2
	Тэнцэл	-	-1,575.2	53.7	-880.6	-1,150.1	-1,888.4	-738.3	64.2

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо

4.2. Экспорт:

2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр экспортын худалдаа 15,184.5 сая ам.доллар болж, өнгөрсөн оноос 2,645.9 сая ам.доллар буюу 21.1 хувиар, 2019 он (Цар тахлын өмнөх үе)-той харьцуулахад 7,564.9 сая ам.доллар буюу 2 дахин өссөн байна.

График 11. Экспорт, бүлгээр



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2019 онтой харьцуулахад 2021-2023 онуудад эрдсийн болон эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт хоёулаа өссөн байна. 2019 онтой харьцуулахад 2020 онд эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт өсөж, харин эрдэс бүтээгдэхүүний экспорт буурсан байна.

2023 онд эрдэс бүтээгдэхүүний экспорт 13,145.6 сая ам.доллар болж, 2,602.3 сая ам.доллар буюу 24.7 хувиар өссөн нь нийт экспортын өсөлтөд голлон нөлөөлжээ. Эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт 2,038.9 сая ам.долларт болж 43.6 сая ам.доллар буюу 2.2 хувиар өссөн.

2023 онд эрдсийн бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувийн жин 86.6 хувь болж, өнгөрсөн оноос 2.5 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 13. Экспорт, бүлгээр /2019-2023 он/

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэл					Өөрчлөлт	
	2019	2020	2021	2022	2023	Дүн	Хувь
Нийт экспорт	7,619.6	7,576.3	9,241.1	12,538.6	15,184.5	2,645.9	21.1
Үүнээс:							
1. Эрдэс бүтээгдэхүүний экспорт	6,377.5	5,256.0	7,510.4	10,543.3	13,145.6	2,602.3	24.7
Эрдэс бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь	83.7	69.4	81.3	84.1	86.6	-	2.5
2. Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	1,242.1	2,320.3	1,730.7	1,995.3	2,038.9	43.6	2.2

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүнд нүүрс, зэсийн баяжмал, алт, төмрийн хүдэр, түүхий газрын тос, жоншны баяжмал, цайрын баяжмал зэрэг бүтээгдэхүүн хамаарч байна.

Нийт экспортын орлогын 58.6 хувийг нүүрс, 17.3 хувийг зэсийн баяжмал, 4.9 хувийг алт, 2.9 хувийг төмрийн хүдэр, 2.4 хувийг боловсруулаагүй нефть, 1.8 хувийг жоншны баяжмал тус тус эзэлж байна.

Өнгөрсөн онтой харьцуулахад зэсийн баяжмал, алт, цайрын баяжмалаас бусад эрдсийн бүтээгдэхүүний экспортын орлого өссөн байна.

Хүснэгт 14. Гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Гол нэр төрлийн бараа	Жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэл					Өөрчлөлт	
	2019	2020	2021	2022	2023	Дүн	Хувь
Нүүрс (сая.т)	36.6	28.7	16.1	31.8	69.6	37.8	118.7
Зэсийн баяжмал(мян.т)	1403.6	1395.1	1282.5	1453.3	1524.8	71.5	4.9
Алт (тн)	9.1	30.5	17.3	19.7	11.7	-7.9	-40.3
Төмрийн хүдэр (сая.т)	8.4	8.2	7.1	4.7	5.7	1.0	20.7
Боловсруулаагүй нефть (мян.барр)	6.5	4.1	4.3	2.6	4.7	2.1	81.5
Жоншны баяжмал (мян.т)	699.4	678.9	644.3	387.7	1087.8	700.1	180.6
Цайрын баяжмал (мян.т)	134.8	134.1	112.6	141.2	150.5	9.3	6.6
Молибдены баяжмал (мян.т)	5.7	6.4	7.3	6.5	6.4	-0.1	-1.3
Тунгаасан зэс (мян.тн)	11.9	9.6	9.8	10.0	12.5	2.5	25.3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 15. Гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/


Гол нэр төрлийн бараа	Экспортод эзлэх хувь	Жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэл					Өөрчлөлт	
		2019	2020	2021	2022	2023	Дүн	Хувь
Нүүрс	58.6	3,078.8	2,126.6	2,774.1	6,503.2	8,898.1	2,394.9	36.8
Зэсийн баяжмал	17.3	1,795.9	1,778.0	2,899.9	2,734.8	2,625.4	-109.5	-4.0
Алт	4.9	418.4	1,787.7	1,004.5	1,127.4	738.0	-389.4	-34.5
Төмрийн хүдэр	2.9	576.6	639.7	952.2	391.0	444.8	53.7	13.7
Боловсруулаагүй нефть	2.4	366.7	150.9	273.4	241.8	364.7	122.9	50.8
Жоншны баяжмал	1.8	205.3	156.3	144.0	110.5	272.4	161.9	146.5
Цайрын баяжмал	1.5	189.0	167.7	176.4	283.3	220.0	-63.3	-22.4
Молибдены баяжмал	0.8	49.0	40.7	82.4	87.2	120.5	33.3	38.2
Тунгаасан зэс	0.7	68.9	59.3	88.5	82.6	102.5	20.0	24.2

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өсөхөд голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

Нүүрс: 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 69.6 сая тонн нүүрс экспортолж, 8.9 тэрбум ам.долларын экспортын орлого олжээ. Өнгөрсөн онтой харьцуулахад экспортын биет хэмжээ 2.2 дахин өсөж, нүүрсний экспортын орлого 2.4 тэрбум ам.доллаароор буюу 36.8 хувиар өссөн байна. Доорх графикаас харахад нүүрсний экспортын орлого нэмэгдэхэд нүүрсний экспортын тоо хэмжээ өссөн нь голлон нөлөөлжээ. 2023 онд сард 3.6-7.9 сая тонны нүүрс экспортолж байсан нь өмнөх онуудтай харьцуулахад өндөр үзүүлэлт юм.


График 12. Нүүрсний экспортын өөрчлөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Төмрийн хүдэр: 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 5.7 сая.тонн төмрийн хүдэр экспортолж, 444.8 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Өнгөрсөн оноос төмрийн хүдрийн экспортын орлого 13.7 хувь буюу 53.7 сая ам.доллараар өссөн. Үүнд; төмрийн хүдрийн экспортын тоо хэмжээ 1.0 сая.тн-оор өссөн нь нөлөөлжээ. Экспортын дундаж үнэ 77.9 ам.доллар болж өнгөрсөн оноос 5.8 хувиар буурчээ.

График 13. Төмрийн хүдрийн экспортын өөрчлөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Боловсруулаагүй нефть: 2023 онд 4.7 сая баррель боловсруулаагүй нефть экспортолж, 364.7 сая ам.долларын орлого олсон байна. Өнгөрсөн онтой харьцуулахад боловсруулаагүй нефтийн экспортын орлого 122.9 сая ам.доллар буюу 50.9 хувиар өссөн. Үүнд боловсруулаагүй нефтийн тоо хэмжээ 2.1 сая баррелиар нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн.

Өнгөрсөн онтой харьцуулахад экспортын орлого буурсан эрдсийн бүтээгдэхүүнийг авч үзвэл:

Алт: 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 11.7 тонн алт экспортолж, экспортын орлого 738.0 сая ам.доллар болж, өмнөх оноос 34.5 хувиар буурсан байна. Өнгөрсөн оноос алтны экспортын тоо хэмжээ 7.9 тонн буюу 40.3 хувиар буурсан нь алтны экспортын орлогыг буурахад нөлөөлсөн байна. 2020-2022 онд 17.3-30.5 тонн алт экспортолсон байна.

Зэсийн баяжмал: 2023 онд 1,524.8 мянган тонн зэсийн баяжмал экспортолж, экспортын орлого 2,625.4 сая ам.доллар болж, өнгөрсөн оноос 109.5 сая ам.доллар буюу 4.0 хувиар буурсан байна. Өнгөрсөн онтой харьцуулахад зэсийн баяжмалын экспорт 71.5 мянган тонноор өссөн хэдий ч экспортын дундаж үнэ нь 160.1 ам.доллар буюу 8.5 хувиар буурсан байна.

График 14. Зэсийн баяжмалын экспортын өөрчлөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Цайрын баяжмал: 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр цайрын баяжмалын экспортын тоо хэмжээ 150.5 мянган тоннд хүрч, 220.0 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Цайрын баяжмалын биет хэмжээ өнгөрсөн оноос 6.6 хувь буюу 9.3 мянган тонноор өссөн хэдий ч хилийн дундаж үнэ өмнөх оноос 576.2 ам.доллороор буюу 27.1 хувиар буурсан нь цайрын баяжмалын экспортын орлого 63.3 сая ам.доллар буюу 22.4 хувиар буурахад нөлөөлжээ.

Хөдөө аж ахуйн түүхий эдийн экспорт: 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 5.4 мянган тонн бохир ноолуур, 1.0 мянган тонн самнасан ноолуур, 17.7 мянган тонн хонины самнаагүй ноос, 517.3 тонн богийн өлөн гэдэс зэрэг хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг экспортолжээ.

Өнгөрсөн онтой харьцуулахад адууны махны экспортын тоо хэмжээ 32.9 мянган тонн болж 5 дахин нэмэгдэж, 125.4 сая ам.долларын орлого олжээ.

Ноолуур, хонины ноос, адууны мах болон богийн өлөн гэдэсний нийт экспорт 510.4 сая ам.доллар болж, нийт экспортын 3.4 хувийг эзэлж байна.

Хүснэгт 16. Зарим хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын орлого

Төрөл	Жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэл					Өөрчлөлт		Экспортод эзлэх хувь
	2019	2020	2021	2022	2023	Дүн	Хувь	
Бохир ноолуур	283.3	185.3	253.6	308.4	263.9	-44.5	-14.4	1.7%
Самнасан ноолуур	45.3	16.9	39.9	93.1	95.9	2.8	3.0	0.6%
Хонины самнаагүй ноос	20.3	8.9	5.4	14.8	13.9	-0.9	-6.1	0.1%
Богийн өлөн гэдэс	8.5	8.9	15.3	15.9	11.2	-4.7	-29.6	0.1%
Адууны мах	57.7	33.3	14.4	21.1	125.4	104.3	Т а в д а х и н ө с с ө н	0.8%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 17. Зарим хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ


Төрөл	Жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэл					Өөрчлөлт	
	2019	2020	2021	2022	2023	Дүн	Хувь
Бохир ноолуур, мян.тн	5.7	6.3	6.0	6.4	5.4	-1.0	-15.6
Самнасан ноолуур, тн	507.2	260.0	424.0	857.0	1,001.0	144.0	16.8
Хонины самнаагүй ноос, мян.тн	14.7	8.5	5.3	17.7	13.3	-4.4	-24.9
Богийн өлөн гэдэс, тн	419.5	503.1	642.9	632.4	517.3	-115.1	-18.2
Адууны мах, мян.тн	30.8	17.7	6.9	6.9	32.9	26.0	3.7 дахин өссөн

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

4.3. Импорт:

2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр нийт импортын худалдаа 9,252.5 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оноос 6.3 хувь буюу 548.1 сая ам.доллараар өссөн.

График 15. Импорт, бүлгээр



2023 онд нийт импортын 23.1 хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, 76.9 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт эзэлж байна. Эрдсийн бүтээгдэхүүний импорт 2,140.3 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оноос 180.0 сая ам.доллар буюу 9.2 хувиар өссөн байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт 5,185.3 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 233.8 сая ам.доллар буюу 4.7 хувиар өсжээ.

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 18. Импорт, бүлгээр /2019-2023 он/

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэл					Өөрчлөлт	
	2019	2020	2021	2022	2023	Дүн	Хувь
Нийт импорт	6,127.4	5,298.9	6,845.5	8,704.4	9,252.5	548.1	6.3
Үүнээс:							
1. Эрдэс бүтээгдэхүүний импорт	1,372.3	1,007.2	1,338.6	1,960.3	2,140.3	180.0	9.2
Эрдэс бүтээгдэхүүний нийт импортод эзлэх хувь	22.4	19.0	19.6	22.5	23.1	-	-
Эрдэс бүтээгдэхүүний нийт импортод эзлэх хувь	22.4	19.0	19.6	22.5	23.1	-	-

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2023 оны гүйцэтгэлээр нийт импортын 29.0 хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 41.0 хувийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 9.0 хувийг аж үйлдвэрлэлийн орц, 20.0 хувийг нефтийн бүтээгдэхүүн эзэлсэн байна.

Хүснэгт 19. Гол нэр төрлийн импортын барааны гүйцэтгэл

/сая ам.доллар/


Бүтээгдэхүүн	Жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэл						Өөрчлөлт (сая ам.дол)
	2021		2022		2023		
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	2023 / 2022
Хэрэглээ	2,184.0	32	2,686.0	31	2,691.0	29	5.0
- Түргэн эдэлгээтэй	1,315.0	19	1,501.0	17	1,363.0	15	-138.0
- Удаан эдэлгээтэй	869.0	13	1,185.0	14	1,329.0	14	144.0
Хөрөнгө оруулалт	2,757.0	40	3,308.0	38	3,820	41	512.0
- Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	1,768.0	26	1,987.0	23	2,411.0	26	424.0
- Барилгын материал	727.0	11	1002.0	12	1,100.0	12	98.0
- Хөрөнгө оруулалтын бусад бараа	262.0	4	318.0	4	309.0	3	-.0
Аж үйлдвэрлэлийн орц	762.0	11	966.0	11	852.0	9	-114.0
- Хүнсний орц	97.0	1	32.0	0	45.0	0	13.0
- Химийн бүтээгдэхүүн	134.0	2	252.0	3	161.0	2	-91.0
- Цахилгаан эрчим хүч	161.0	2	182.0	2	186.0	2	4.0
- Бусад АҮ-ийн орц	370.0	6	500.0	6	460.0	5	-40.0
Нефтийн бүтээгдэхүүн	1,132.0	17	1,724.0	20	1,869.0	20	145.0
- Дизель	590.0	9	960.0	11	1,110	12	150.0
- АИ-92, 95	353.0	5	535.0	6	509.0	5	-26.0
- А80 ба бусад	189.0	3	229.0	3	250.0	3	21.0
Бусад	11		21		20		-1.0
Нийт дүн	6,845.0	100	8,704.0	100	9,252.0	100	548.0

Эх сурвалж: Монголбанк

2022 онтой харьцуулахад 2023 онд импортын худалдаа 548.0 сая ам.доллараар нэмэгдэхэд хөрөнгө оруулалт 512.0 сая, нефтийн бүтээгдэхүүн 145.0 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлжээ. Үүний дотор машин, механик тоног төхөөрөмж, эд анги 424.0 сая ам.доллар, дизель түлш 150.0 сая ам.доллар, барилгын материал 98.0 сая. ам. доллар, удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн 144.0 сая ам.доллараар тус тус нэмэгдсэн байна.

Нефтийн бүтээгдэхүүний импорт нь өнгөрсөн оноос 145.0 сая ам.доллараар өссөн байна. Үүнд нефтийн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ буурсан хэдий ч тоо хэмжээ 25.5 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Дизель түлшний импорт 150.0 сая ам.доллараар нэмэгджээ. 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр нефтийн бүтээгдэхүүний хилийн дундаж үнэ 111.1 ам.дол/баррель болж, 2022 оны жилийн эцсээс 21.4 ам.доллар буюу 16.2 хувиар буурсан байна.

График 16. Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ДӨРӨВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ**5.1. Мөнгөний нийлүүлэлт:**

Мөнгөний нийлүүлэлт 2023 оны 12 дугаар сарын байдлаар 37,624.1 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 7,959.3 тэрбум төгрөг буюу 26.8 хувиар өссөн байна.

Өнгөрсөн онтой харьцуулахад мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд төгрөгийн харилцах 2,577.4 тэрбум төгрөг буюу 40.5 хувиар, төгрөгийн хадгаламж 4,529.4 тэрбум төгрөг буюу 36.0 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 20. Мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтүүд

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэл			Өөрчлөлт (+/-)	
				2023/2022	
	2021	2022	2023	Дүн	Хувь
Мөнгөний нийлүүлэлт (M2)	27,863.5	29,664.8	37,624.1	7,959.3	26.8
Мөнгө M1	6,507.2	7,201.3	9,853.1	2,651.8	36.8
Төгрөгийн харилцах	5,660.0	6,370.2	8,947.6	2,577.4	40.5
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	847.2	831.1	905.5	74.4	9.0
Бараг мөнгө	21,356.3	22,463.5	27,770.9	5,307.4	23.6
Төгрөгийн хадгаламж	15,006.7	12,590.2	17,119.6	4,529.4	36.0
Валютын хадгаламж	3,921.1	4,694.2	4,813.8	119.6	2.5
Валютын харилцах	2,344.5	4,946.8	5,646.9	700.1	14.2
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	1,105.6	1,089.2	1,151.7	62.5	5.7

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 27.4 их наяд төгрөг болж, өнгөрсөн оноос 5.1 их наяд төгрөг буюу 23.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 21. Зээлийн өрийн үлдэгдэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэл			Өөрчлөлт (+/-)	
				2023/2022	
	2021	2022	2023	Дүн	Хувь
Зээлийн өрийн үлдэгдэл	20,876.4	22,241.7	27,373.7	5,132.0	23.1
-Хэвийн зээл	17,857.2	19,086.2	24,061.9	4,975.7	26.1
-Хугацаа хэтэрсэн зээл	938.1	1,128.7	1,272.7	144.0	12.8
-Чанаргүй зээл	2,081.1	2,026.8	2,039.0	12.2	0.6
Чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	10.0	9.1	7.4	-	-
Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	4.5	5.1	4.6	-	-

Эх сурвалж: Монголбанк

Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 57.0 хувь нь иргэдийнх, 41.9 хувь нь хувийн хэвшлийн байгууллагынх эзэлж байна. Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл 2023 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар 24,061.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 4,975.7 тэрбум төгрөг буюу 26.1 хувиар өссөн байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 87.9 хувийг хэвийн зээл, 7.4 хувийг чанаргүй зээл, 4.6 хувийг хугацаа хэтэрсэн зээл эзэлж байна. Өнгөрсөн онтой харьцуулахад чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь хэмжээ 1.7 нэгж хувиар буурчээ.


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл: 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр хугацаа хэтэрсэн зээл 1,272.7 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оноос 144.0 тэрбум төгрөг буюу 12.8 хувиар өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.6 хувийг эзэлж, өнгөрсөн оноос 0.5 нэгж хувиар буурсан байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээлийн хэмжээ: 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр чанаргүй зээлийн хэмжээ 2.0 их наяд төгрөг болж, өнгөрсөн оноос 12.2 тэрбум төгрөг буюу 0.26хувиар буурчээ. Чанаргүй зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.4 хувийг эзэлж байна.

Үнэт цаас: Үнэт цаасны арилжаагаар 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 725.9 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 1,148.3 сая ширхэг үнэт цаас арилжаалсан байна. Өнгөрсөн онтой харьцуулахад үнэт цаасны арилжааны гүйлгээ 174.7 тэрбум төгрөгөөр, арилжаалсан үнэт цаас 548.0 сая ширхгээр тус тус нэмэгдсэн байна. Нийт арилжааны 67.3 хувь нь хувьцааны, 17.6 хувь нь хөрөнгө оруулалтын сангийн эрхийн, 13.7 хувь нь компанийн бондын 8.4 хувь нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа тус тус эзэлж байна. 2023 оны эцсийн байдлаар хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны нийт үнэлгээний дүн 11.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 4.7 их наяд төгрөг буюу 68.7 хувиар өссөн байна. Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2023 оны жилийн эцсийн байдлаар 38,553.9 нэгж болж, өмнөх оноос 2,377.1 нэгжээр өссөн байна.

Валютын ханш: Төгрөгийн ам.доллартой харьцах нэрлэсэн ханш 2023 оны 12 дугаар сард 3,421.0 төгрөг болж, өмнөх оноос 10.1 төгрөгөөр чангарсан байна. Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш 476.0 төгрөг болж, өмнөх оноос 12.9 төгрөгөөр мөн чангарсан байна.

График 17. АНУ-ын доллар ба БНХАУ-ын юанийн ханш, 2023.12 сар /төгрөгөөр/



Эх сурвалж: Монголбанк

Хэрэглээний үнийн индекс:

Хэрэглээний үйлчилгээний үнэ 2023 оны 12 дугаар сард улсын хэмжээнд 7.9 хувьтай гарч, өмнөх оны мөн үеэс 5.3 нэгж хувиар буурсан байна.

2020-2022 онд тээвэр логистикийн хүндрэл, нийлүүлэлтийн саатлаас үүдэлтэйгээр хүнсний бүтээгдэхүүн, эрчим хүч, үйлчилгээний үнэ өссөн нь дэлхийн улс орнуудад инфляц өндөр байхад голлон нөлөөлсөн. Монгол Улсын хувьд мөн шалтгааны улмаас удаан хугацаанд буюу 25 сарын туршид инфляц 10-аас дээш хувьтай байснаа 2023 оны 9 дүгээр сараас хойш 10-аас доош түвшин рүү орсон байна.

График 18. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, сар бүрийн өөрчлөлт, хувиар




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

5.2. Гадаад валютын албан нөөц:

Нийт албан нөөцийн хэмжээ 2023 оны эцсээр 4,921.5 сая ам.доллар болж, өнгөрсөн оноос 1,522.0 сая ам.доллар буюу 44.8 хувиар өссөн байна.

График 19. Нийт гадаад валютын албан нөөц /сая ам.доллароор/



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2023 оны эцсийн байдлаар 4,921.5 сая ам.доллар болж нийт импортын 6.4 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрсэн байна. Өнгөрсөн онтой харьцуулахад гадаад валютын албан нөөц 1,522.0 сая ам.доллараар өссөн нь нийт импортын хэрэгцээг хангах түвшнийг 1.7 сараар нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт 22. Гадаад валютын албан нөөц ба импорт


/сая ам.доллар/

№	Үзүүлэлт	Жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэл				
		2019	2020	2021	2022	2023
1	Нийт импорт	6,127.4	5,298.9	6,845.5	8,704.4	9,252.5
2	Гадаад валютын нийт нөөц	4,348.6	4,534.2	4,366.1	3,399.6	4,921.5
3	Импортын хэрэгцээг хангах түвшин /сар/	8.5	10.3	7.7	4.7	6.4

Эх сурвалж: Монголбанк, Гаалийн ерөнхий газар

Худалдан авсан алт: Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 17.8 тонн болж, 2022 оноос 5.1 тонноор буурч, сүүлийн 4 жилийн хамгийн бага дүн болж байна.

График 20. Монгол банкны худалдан авсан алтны хэмжээ, 2012-2023 оны гүйцэтгэл /тонн/



Эх сурвалж: Монголбанк

5.3. Төлбөрийн тэнцэл:

Төлбөрийн тэнцэл нь урсгал тэнцэл, хөрөнгө ба санхүүгийн тэнцлээс бүрддэг. 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр урсгал тэнцэл 244.5 сая ам.доллар, хөрөнгийн тэнцэл 135.2 сая ам.доллар, санхүүгийн тэнцэл 1,376.0 сая ам.долларын ашигтай тус тус гарсан. Төлбөрийн тэнцлийн урсгал тэнцэл, хөрөнгө ба санхүүгийн тэнцлүүд ашигтай гарсан нь төлбөрийн тэнцэл нийт дүнгээрээ 1,457.0 сая ам.долларын ашигтай гарахад нөлөөлжээ. Төлбөрийн тэнцэл өнгөрсөн оноос 2,184.2 сая ам.доллараар сайжирсан байна.

2023 оны байдлаар урсгал тэнцэл ашигтай гарахад бараа, үйлчилгээний худалдааны тэнцэл 1,743.4 сая ам.доллар, мөн хоёрдогч орлого 395.2 сая ам.долларын ашигтай гарсан нь голлон нөлөөлсөн. 2023 онд хөрөнгийн тэнцэл 135.6 сая ам.доллар, мөн санхүүгийн тэнцэл 1,376.0 сая ам.долларын ашигтай тус тус гарсан байна.


Хүснэгт 23. Төлбөрийн тэнцэл

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэл			Өөрчлөлт
	2021	2022	2023	Дүн
I. Урсгал Тэнцэл	-2,108.4	-2,303.5	244.5	2,548.0
А. Бараа ба үйлчилгээний худалдаа	-305.7	-1,122.5	1,743.4	2,865.9
В. Анхдагч орлого	-2,231.8	-1,615.1	-1,894.0	-278.9
С. Хоёрдогч орлого	429.1	434.1	395.2	-38.9
II. Хөрөнгийн тэнцэл	114.0	154.2	135.6	-18.6
III. Санхүүгийн тэнцэл	1,982.2	1,644.1	1,376.0	-268.1
IV. Алдаа болон орхигдуулга	-209.4	-222.1	-299.2	-77.1
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	-221.6	-727.2	1,457.0	2,184.2

Эх сурвалж: Монголбанк

График 21. Төлбөрийн тэнцэл, 2009-2023 он



Эх сурвалж: Монголбанк

ЗУРГАА. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

6.1. Хүн ам, ажил эрхлэлт


2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр улсын хэмжээнд 66.7 мянган хүүхэд шинээр төрсөн байна. 2023 онд нийт ажиллах хүчний тоо 1,245.6 мянга болж, өнгөрсөн оноос 22.8 мянга буюу 1.9 хувиар нэмэгдсэн байна. Ажиллах хүчнээс 1,196.8 мянган хүн нь ажилтай, 48.8 мянган иргэд нь ажилгүй хүмүүс байна. Өнгөрсөн онтой харьцуулахад 2023 онд ажилтай иргэдийн тоо 38.6 мянгаар нэмэгдэж, ажилгүй хүмүүсийн тоо 15.8 мянгаар буурсан байна.

Улсын хэмжээнд ажиллах хүчний оролцооны түвшин 57.6 хувь, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 55.4 хувь байна. Мөн 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн ам 915.9 мянга байна.

6.2. Ажилгүйдлийн түвшин

2023 онд улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 3.9 хувьтай болж, өмнөх улирлаас 1.3 нэгж хувиар, өнгөрсөн оноос 1.4 нэгж хувиар тус тус буурсан байна. Энэ нь өмнөх оноос ажилгүй хүний тоо буурч, ажилтай иргэдийн тоо нэмэгдэн эдийн засаг идэвхжиж, ажил эрхлэлт нэмэгдсэнтэй холбоотой байна.

График 18. Ажилгүйдлийн түвшин, хувиар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС